



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/232

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн XVIII хуралдааны 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд “Хот, хөдөөгийн сэргэлт” зорилтыг хэрэгжүүлэх, “Нээлттэй Хөвсгөл-Эдийн засаг, хөрөнгө оруулалтын чуулган” арга хэмжээг 2023 оны эхний хагас жилд багтаан зохион байгуулсугай.

2. “Нээлттэй Хөвсгөл-Эдийн засаг, хөрөнгө оруулалтын чуулган”-ыг төр хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын оролцоог хангаж хамтран зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн чиг үүргийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. “Нээлттэй Хөвсгөл-Эдийн засаг, хөрөнгө оруулалтын чуулган” арга хэмжээний удирдамж, төсөв, бэлтгэл ажлын төлөвлөгөөг 2023 оны 05 дугаар сарын 20-ны дотор боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх, “Нээлттэй Хөвсгөл- Эдийн засаг, хөрөнгө оруулалтын чуулган” арга хэмжээг зохион байгуулж дууссанаас хойш ажлын тав хоногт багтаан тайлан мэдээг танилцуулахыг Ажлын хэсэг (М.Хуягбаатар)-д даалгасугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2023 оны
05 дугаар сарын 11-ний өдрийн
А/232 дүгээр захирамжийн нэгдүгээр
хавсралт

**“НЭЭЛТТЭЙ ХӨВСГӨЛ-ЭДИЙН ЗАСАГ, ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ЧУУЛГАН”-ЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХЫГ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн дарга: Аймгийн Засаг даргын орлогч

Ажлын хэсгийн дэд дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

- Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- Мөрөн сумын Засаг дарга
- Аймгийн Соёл, урлагийн газрын дарга
- Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
- Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга
- Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга
- Аймгийн Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газрын дарга
- Аймгийн Хөгжимт драмын театрын дарга
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга
- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга
- Татварын хэлтсийн дарга
- Эрүүл мэндийн газрын дарга
- Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ны Хөвсгөл салбарын дарга
- Хөвсгөл Политехникийн коллежийн захирал
- МҮХАҮТ-ын Хөвсгөл аймаг дахь салбарын дарга /тохиролцсоноор/
- Хөвсгөл Дулааны станц ТӨҮГ-ын дарга
- Хөвсгөл Эрчим хүч ХХК-ийн захирал

Нарийн бичгийн дарга: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

_____оОо_____